



**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт буурч, айл өрхийн амьжиргаа, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл, сорилт учирсан. Манай улсын эдийн засгийн өсөлт 2020 онд 4.6 хувиар буурч, 1992 оноос хойш хамгийн өндөр хувиар агшсан байна. Сүүлийн саруудад худалдаа, үйлчилгээ хэвийн горимд үе шаттай шилжиж, эдийн засагт сэргэлт ажиглагдаж, гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ нээгдэн эдийн засаг аажмаар сэргэж байгаа ч хямралаас бий болсон хохирлыг нөхөж чадахгүй, эдийн засгийн салбарууд эмзэг хэвээр байна. Мөн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын шинэ хувилбарууд гарч нөхцөл байдал цаашид хэр удаан үргэлжлэх нь тодорхой бус, эрсдэлтэй байгаа нь улс орны эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эдийн засаг дахь сөрөг нөлөөлөл, болзошгүй эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, эдийн засгийг эрчимжүүлэх, “Алсын хараа-2050” болон бусад бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтыг ханган ажиллахын тулд Монгол Улсын Их Хурлаас “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталсан.

Монгол Улсын Их Хурлаас баталсан дээрх тогтоолын 4 дүгээр хавсралтаар Монгол Улсын Их Хурлаар нэн яаралтай хэлэлцэх хуулийн төслийн жагсаалтыг баталсан бөгөөд уг хавсралтын 5 дахь заалтад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэн яаралтай боловсруулж 2022 оны 01 дүгээр сард багтаан Монгол Улсын Их хуралд өргөн мэдүүлэхээр заасан нь хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд дараах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хуулиар өөрчлөн баталсан бол гэрээний үнийг нэг удаа өөрчлөх боломжтой байх;

- Монгол Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн төслийн жагсаалтад орсон төсөл, арга хэмжээтэй холбогдуулан тендер шалгаруулалтыг хялбаршуулах, шаардагдах санхүүжилтийн 30-аас доош хувийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд санхүүжүүлэх тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй байх;

- Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувь байсныг 3 хувь болгон бууруулах;

- Тендерийн баталгаа 2 хувь байсныг 0.5 хувь болгон бууруулах;

- Зүгшрүүлэх, тохируулах хугацааны барьцаа 5-10 хувь байсныг 5 хувь байхаар тус тус тогтоож, барьцааны хугацаа 4 жил байсныг 1 жил болгож бууруулах;

- Тендерийг 30 хоногт багтаан зохион байгуулдаг байсныг ажлын 15 хоногт багтаан зохион байгуулах;

- Тендер шалгаруулалттай холбогдуулан гомдол гарсан бол гэрээ байгуулах хугацаа түр зогсох.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн төслийн худалдан авах ажиллагааг хялбаршуулж, хөгжлийн төслүүдийг хугацаа алдалгүй түргэн шуурхай зохион байгуулах боломж бүрдэнэ;

- Тендерт оролцох зардал буурч, хурдан шуурхай зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

- Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ, зүгшрүүлэх, тохируулах хугацааны барьцаа буурснаар тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн дарамт буурч, мөнгөн хөрөнгийн урсгал нэмэгдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулах ба хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.